

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 04 дүгээр сарын 26
Тендер шалгаруулалтын нэр: **Тусгай зориулалттай автомашины даацын дугуй** нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: **ХХ-2017/03-06**

Эрдэнэт үйлдвэр ХХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Тусгай зориулалттай автомашины даацын дугуй** нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн баримт бичгийн төлбөрийг Худалдаа хөгжлийн банкны Орхон аймгийн салбар дахь Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 407 016 667 тоот дансанд төлсөн байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 3 жил /2014 он, 2015 он, 2016 он/**

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 3 жил (2014 он, 2015 он, 2016 он)-ийн аль нэг жилд гүйцэтгэсэн нийт борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **50 000 000 төгрөг /тавин сая/ -өөс багагүй байна.**

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн **1%**-тай тэнцэх төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 10 цаг 50 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Ерөнхий захиргааны II байр, 347 тоот өрөө,

Утас: 01-352-73371, 01-352-73790

Факс: 70353002

Вэб сайт: www.erdenetmc.mn

E-mail: b.oyunchimeg@erdenetmc.mn